



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Томилолтоор ажиллуулах тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. БНСУ-ын “КАН” ХХК-ний боловсруулан батлуулсан Дорнод аймгийн Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэж буй шинэ суурьшлын бүтээн байгуулалтыг судлан хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн Ахлагч

Ерөнхий инженер бөгөөд
барилгын инженер

Г.Пүрэвдорж

Ажлын хэсгийн гишүүд

Усан хангамж, ариутгах
татуургын инженер

Ч.Батхишиг

Дулааны цахилгаан
станцын инженер

Т.Эрдэнэсайхан

Үйл ажиллагааны төлөвлөлт
хариуцсан эдийн засагч

С.Ариунбилэг

Архитектор

Э.Төмөртогтох

2. Ажлын хэсгийг 2016 оны 05 дугаар сарын 25-аас 27-ны хооронд Дорнод аймагт ажиллахыг зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгийн Улаанбаатар-Дорнод-Улаанбаатар маршрутын 1800 км зам туулахад зарцуулагдах 360л түлшний үнэ 570,000 төгрөгийг тээвэр шатахууны зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч Г.Батнямд зөвшөөрсүгэй.

4. Ажлын хэсгийн тайланг 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн шуурхай зөвлөгөөн дээр танилцуулахыг ажлын хэсгийн Ахлагч Г.Пүрэвдоржид үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн А.Нямхүүд даалгасугай.

ДАРГА  М.ГОНЧИГЖАВ



3150600041